



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙД
Л.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.04.03 № 15

Г Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний талаар Г

Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт Үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 792,000 (долоон зуун ерэн хоёр) мянган төгрөг болгож нэмэгдүүлэх шийдвэр гаргасан.

Энэхүү шийдвэртэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна.

1.Үндэсний хорооны 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 12 дугаар тогтоолоор хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 660,000 (зургаан зуун жаран) мянган төгрөг байхаар тогтоосон байхад 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс дахин нэмэгдүүлэх шийдвэр гаргасан нь Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан "...хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр жилд нэг удаа тогтоох...", 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасан хугацааг зөрчсөн эсэх талаар;

2.Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс нэмэгдүүлснээр цалин хөлсөнд уялдуулах эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал, улсын төсөвт үзүүлэх ачааллын талаарх тооцоолол бүхий мэдээлэл;

3.Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2, 144.3 дахь хэсэгт заасны дагуу төлбөр төлөх хичнээн аж ахуйн нэгж, байгууллага байгаагаас хэд нь тус төлбөрийг төлж байгаа, мөн гадаадаас ажиллах хүч авч байгаа аж ахуйн нэгж, байгууллагад үзүүлж байгаа нөлөөлөл зэргээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлснээр үүсэх нөлөөллийг хэрхэн тооцсон талаарх мэдээлэл, тооцоо судалгааг ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН



А.АРИУНЗАЯА

2025000019